

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код:ЗАА-2022/01/СТА-ТӨХК

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай хот  
2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа  
Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn  
Ахлах аудитор : Б.Дагвасүрэн  
Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn  
Аудитор П.Ганцолмон  
Утас:70157405 Цахим хаяг:ulistaivanaudit@ubaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>1. Аудитын санал дүгнэлт</b>	2
<b>2. Аудит хийсэн санхүүгийн тайлан</b>	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
<b>3. Санхүүгийн тайлангийн аудитын тодруулга</b>	
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
<b>4. Аудитын тайлан</b>	
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Дотоод хяналт	12
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
4.4 Материаллаг байдал	13
<b>5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
<b>6. Засврын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b>	14
<b>7. Дараагийн аудитаар анхаарах асуудал</b>	14
<b>8. Аудитын илрүүлэлт</b>	14
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	15
<b>9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл</b>	15

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1. Аудитын санал дүгнэлт

  
**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ НИСЭХ  
БУУДАЛ ТӨХК-ИЙН ДАРГА П.ЭНХБОЛД-д

2022.03.15 № 1302-4/19  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

01302545

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,177,792.97	13,217,265.35
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	15,893.59	-
1.1.4	Бусад авлага	176,214.47	274,011.50
1.1.6	Бараа материал	201,320,166.45	191,584,702.26
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		380,000.00
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>208,690,067.48</b>	<b>205,455,979.11</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	423,643,957.13	420,040,709.04
1.2.2	Биет бус хөрөнгө	4,190,180,059.06	4,189,773,000.71
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	30,061,556.73	28,390,388.79
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>4,643,885,572.92</b>	<b>4,638,204,098.54</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,852,575,640.40</b>	<b>4,843,660,077.65</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1.</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1.3	Татварын өр	-	2,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	315,893.59	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>315,893.59</b>	<b>2,000.00</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	4,186,718,000.00	4,186,718,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	104,153,753.87	104,153,753.87
2.3.9	Хуримтлагдсан ашиг	561,387,992.94	552,786,323.78
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,852,259,746.81</b>	<b>4,843,658,077.65</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,852,575,640.40</b>	<b>4,843,660,077.65</b>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1.1.1</b>	<b>Борлуулалтын орлого</b>		
	Буулт хөөрөлтийн орлого	58,412.82	30,000.00
	Газрын техник үйлчилгээний орлого	91,107.26	278,012.52
	Шатахуун тээвэрлэлийн орлого	-	70,775.00
	<b>Борлуулалтын орлогын дүн</b>	<b>149,520.08</b>	<b>378,787.52</b>
<b>1.2</b>	<b>Борлуулалтын өртөг</b>	<b>801,568,723.24</b>	<b>510,242,019.66</b>
	Бичиг хэрэг	1,674,750.41	744,574.74
	Албан конторын зардал	1,782,681.79	1,833,990.81
	Шатахуун	11,730,648.83	9,691,910.18
	Үндсэн цалин	169,907,145.86	168,763,686.05
	Илүү цаг	11,662,638.66	2,910,982.59
	Амралтын мөнгө	26,173,723.37	26,842,672.75
	Цалингийн бусад нэмэгдэл	45,751,816.92	43,796,662.31
	<b>    Үндсэн ба нэмэгдэл цалингийн нийт дүн</b>	<b>253,495,324.81</b>	<b>242,314,003.70</b>
	Хоолны үнийн хөнгөлөлт	53,160,000.00	48,405,000.00
	Нийгмийн даатгалын зардал (Үйлдвэрлэл)	42,605,253.82	41,575,245.16
	Сэлбэг засвар-Барилга	4,162,787.50	7,128,333.28
	Сэлбэг засвар-Автомашин	1,383,812.78	3,726,440.02
	Сэлбэг засвар-Аэродром	10,084,749.10	9,996,496.57
	Сэлбэг засвар -ТТ	33,746,413.84	10,518,747.35
	<b>    Сэлбэг засвар</b>	<b>49,377,763.22</b>	<b>31,370,017.22</b>
	Цахилгаан	6,462,222.33	6,775,378.17
	Дулаан	27,106,119.07	25,794,814.32
	Холбооны зардал	1,243,499.37	1,107,798.90
	<b>Ашиглалтын зардлын дүн</b>	<b>34,811,840.77</b>	<b>33,677,991.39</b>
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	311,921,373.35	74,125,844.41
	Биет бус хөрөнгийн хорогдуулга	408,173.57	407,058.35
	<b>Элэгдлийн зардлын дүн</b>	<b>312,329,546.92</b>	<b>74,532,902.75</b>
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	843,549.00	1,282,585.34
	Газрын татвар	4,194,008.00	4,093,136.00
	Тээврийн хэрэгслийн татвар	332,500.00	271,800.00
	Хөрөнгийн даатгал	711,000.00	840,000.00
	<b>Татвар, даатгалын зардлын дүн</b>	<b>6,081,057.00</b>	<b>6,487,521.34</b>
	Хөдөлмөр хамгаалалт	8,477,088.80	4,905,015.44
	Дүрэмт хувцас	281,818.18	-
	Дотоод сургалтын зардал	450,000.00	300,000.00
	<b>Сургалтын зардлын дүн</b>	<b>450,000.00</b>	<b>300,000.00</b>
	Дотоод томилолт	20,559,834.25	9,113,393.75
	<b>Албан томилолтын зардлын дүн</b>	<b>20,559,834.25</b>	<b>9,113,393.75</b>
	Харуул хамгаалалт	635,416.80	243,445.38
	Цэвэрлэгээний зардал	513,509.63	563,753.20
	Зорчигч үйлчилгээний зардал	-	53,754.63

	Харуул хамгаалалт	635,416.80	243,445.38
	Цэвэрлэгээний зардал	513,509.63	563,753.20
	Зорчигч үйлчилгээний зардал	-	53,754.63
	Гал команд	1,917,999.83	823,636.33
	Тээврийн зардал	688,670.00	3,300,000.00
	Аудит баталгаажуулалтын зардал	314,200.00	-
	Үйлдвэрлэлийн бусад зардал	681,318.18	305,863.64
<b>1.3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>-801,419,203.16</b>	<b>-509,863,232.14</b>
<b>1.4</b>	<b>Үйл ажиллагаа (Борлуулалт, ерөнхий</b>	<b>108,000.00</b>	<b>720,000.00</b>
	Аудит баталгаажуулалтын зардал	108,000.00	720,000.00
<b>1.5</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>-801,527,203.16</b>	<b>-510,583,232.14</b>
<b>2</b>	<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>852,522,995.22</b>	<b>501,981,562.99</b>
2.6.1	Бусад үйл ажиллагааны бус орлого	865,815,356.58	521,115,340.78
	Хүүгийн орлого	100,139.55	-
	Бусад үйл ажиллагааны бус орлого	596,908.48	576,844.65
	Санхүүжилт орлого	592,831,536.54	518,007,455.94
	Систем хоорондын тооцоогоорх орлого	258,903,779.13	2,531,040.19
	ҮХ-н дотоод хөдөллийн борлуултын олз	13,382,992.88	-
2.6.2	Бусад үйл ажиллагааны бус зардал	13,292,361.36	19,133,777.79
	Шагнал	300,000.00	-
	Тэтгэмж	1,525,000.00	250,000.00
	Түлшний хөнгөлөлт	2,400,000.00	2,800,000.00
	Банкны үйлчилгээний зардал	84,840.00	101,800.02
	Спорт арга хэмжээний зардал	200,000.00	-
	Эмнэлэг үйлчилгээний зардал	301,900.00	240,000.00
	Үйл ажиллагааны бус бусад зардал	1,210,604.17	10,013.96
	Систем хоорондын тооцоогоорх зардал	7,270,017.19	15,731,963.81
<b>2.3</b>	<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн</b>	<b>852,522,995.22</b>	<b>501,981,562.99</b>
<b>3</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>50,995,792.06</b>	<b>-8,601,669.15</b>
<b>4</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>50,995,792.06</b>	<b>-8,601,669.15</b>
<b>5</b>	<b>Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>50,995,792.06</b>	<b>-8,601,669.15</b>
<b>6</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>50,995,792.06</b>	<b>-8,601,669.15</b>

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,186,718,000.00	104,153,753.87	561,387,992.94	4,852,259,746.81
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	4,186,718,000.00	104,153,753.87	561,387,992.94	4,852,259,746.81
4	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-
9	2020 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	4,186,718,000.00	104,153,753.87	561,387,992.94	4,852,259,746.81
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	4,186,718,000.00	104,153,753.87	561,387,992.94	4,852,259,746.81
12	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-8,601,669.15	552,786,323.78
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-
17	2021 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	4,186,718,000.00	104,153,753.87	552,786,323.79	4,843,658,077.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>528,208,093.69</b>	<b>455,499,813.77</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйтчилгээ үзүүлсний орлого	164,472.09	338,813.77
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	527,985,526.00	455,111,000.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	53,805.60	50,000.00
1.1.6.	Банк хоорондын гүйлгээ	4,290.00	
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>459,346,641.85</b>	<b>433,460,341.39</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	269,506,873.62	245,987,922.14
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	77,866,808.45	76,819,910.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	29,071,960.60	38,594,565.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	34,410,926.73	33,377,039.73
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,458,794.00	7,580,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	30,405,178.45	24,112,068.29
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	11,621,810.00	6,988,836.02
1.2.9.	Банк хоорондын гүйлгээ	4,290.00	
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний</b>	<b>68,861,451.84</b>	<b>22,039,472.38</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>100,139.55</b>	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	100,139.55	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>63,037,526.00</b>	<b>16,000,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	63,037,526.00	16,000,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-62,937,386.45</b>	<b>-16,000,000.00</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
3.1.1	Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
3.2.1	Зээл, ерийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн</b>	-	-
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>5,924,065.39</b>	<b>6,039,472.38</b>
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>5,924,065.39</b>	<b>6,039,472.38</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,253,727.58</b>	<b>7,177,792.97</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7,177,792.97</b>	<b>13,217,265.35</b>

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>546,065,749.90</b>	<b>549,828,800.00</b>	<b>540,861,400.00</b>	<b>439,830,900.00</b>	<b>101,030,500.00</b>	
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>533,248,449.90</b>	<b>537,011,500.00</b>	<b>529,901,500.00</b>	<b>434,345,400.00</b>	<b>95,556,100.00</b>	
<b>Цалин, хэлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>376,304,700.00</b>	<b>376,304,700.00</b>	<b>345,628,000.00</b>	<b>290,719,000.00</b>	<b>54,909,000.00</b>	
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	321,104,700.00	321,104,700.00	290,428,000.00	242,314,000.00	48,114,000.00	83%
2	Унаа хоолны хөнгөлөлт	55,200,000.00	55,200,000.00	55,200,000.00	48,405,000.00	6,795,000.00	88%
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>47,038,149.90</b>	<b>50,801,100.00</b>	<b>48,388,000.00</b>	<b>41,575,000.00</b>	<b>6,813,000.00</b>	
4	Тэтгэврийн даатгал	31,985,899.50	31,985,900.00	31,106,500.00	26,882,900.00	4,223,600.00	86%
5	Тэтгэмжийн даатгал	3,763,047.00	3,763,000.00	3,456,300.00	2,938,400.00	517,900.00	85%
6	ҮОМШ-ийн даатгал	3,010,500.00	3,763,000.00	6,221,300.00	5,289,200.00	932,100.00	85%
7	Ажилгүйдлийн даатгал	752,609.40	3,763,000.00	691,300.00	587,600.00	103,700.00	85%
8	Эрүүд мэндийн даатгал	7,526,094.00	7,526,200.00	6,912,600.00	5,876,900.00	1,035,700.00	85%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>34,721,500.00</b>	<b>34,721,600.00</b>	<b>36,970,000.00</b>	<b>32,570,300.00</b>	<b>4,399,700.00</b>	
9	Гэрэл, цахилгаан	7,732,500.00	7,732,600.00	7,577,000.00	6,775,400.00	801,600.00	89%
10.0	Тулш, халаалт	26,989,000.00	26,989,000.00	29,393,000.00	25,794,900.00	3,598,100.00	88%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>20,465,300.00</b>	<b>20,465,300.00</b>	<b>19,720,300.00</b>	<b>17,242,000.00</b>	<b>2,478,300.00</b>	
13	Бичиг хэрэг	1,892,500.00	1,892,500.00	1,201,400.00	744,600.00	456,800.00	62%
14	Тээвэр, шатахуун	14,951,600.00	14,951,600.00	14,056,900.00	12,991,900.00	1,065,000.00	92%
16	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	1,100,000.00	1,748,000.00	1,107,800.00	640,200.00	63%
17	Хөг хаягдал зайлуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгал	684,600.00	684,600.00	878,000.00	563,800.00	314,200.00	64%
18.0	Бага үнэтэй, турган элэгдэх, ахуйн эд зүйлс	1,836,600.00	1,836,600.00	1,836,000.00	1,833,900.00	2,100.00	100%
<b>Нормативт зардал</b>		<b>5,220,000.00</b>	<b>5,220,000.00</b>	<b>4,614,400.00</b>	<b>2,030,900.00</b>	<b>2,583,500.00</b>	<b>44%</b>
19	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,220,000.00	5,220,000.00	4,614,400.00	2,030,900.00	2,583,500.00	44%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>30,343,400.00</b>	<b>30,343,400.00</b>	<b>57,747,000.00</b>	<b>35,068,100.00</b>	<b>22,678,900.00</b>	
<b>Багаж, техник, хэрэгсэл</b>		<b>25,825,800.00</b>	<b>25,825,800.00</b>	<b>51,647,000.00</b>	<b>32,193,900.00</b>	<b>19,453,100.00</b>	
	Барилга	5,000,000.00	5,000,000.00	7,260,000.00	7,128,400.00	131,600.00	98%
	Тоног төхөөрөмжийн	3,382,800.00	3,382,800.00	25,521,000.00	10,518,800.00	15,002,200.00	41%
	Автомашин	5,443,000.00	5,443,000.00	6,445,000.00	3,726,500.00	2,718,500.00	58%
	Аэродром	10,000,000.00	10,000,000.00	11,015,000.00	9,996,500.00	1,018,500.00	91%
	Гал унтраах зардал	2,000,000.00	2,000,000.00	1,406,000.00	823,700.00	582,300.00	59%
	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,517,600.00	4,517,600.00	6,100,000.00	2,874,200.00	3,225,800.00	47%
<b>Томилголт, зочны зардал</b>		<b>12,308,100.00</b>	<b>12,308,100.00</b>	<b>10,310,800.00</b>	<b>9,113,400.00</b>	<b>1,197,400.00</b>	
	Дотоод албан томилголт	12,308,100.00	12,308,100.00	10,310,800.00	9,113,400.00	1,197,400.00	88%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>6,847,300.00</b>	<b>6,847,300.00</b>	<b>6,523,000.00</b>	<b>6,026,700.00</b>	<b>496,300.00</b>	
	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,400,000.00	1,400,000.00	1,000,000.00	720,000.00	280,000.00	72%
	Даатгалын үйлчилгээ	840,000.00	840,000.00	840,000.00	840,000.00	-	100%
	Тээврийн хэрэгслийн татвар	313,300.00	313,300.00	339,000.00	271,800.00	67,200.00	80%
	Мэдээллийн технологийн үйлчилгээ	-	-	-	-	-	
	Газрын төлбөр	4,194,000.00	4,194,000.00	4,194,000.00	4,093,100.00	100,900.00	98%
	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	100,000.00	150,000.00	101,800.00	48,200.00	68%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,535,000.00</b>	<b>315,800.00</b>	<b>1,219,200.00</b>	
	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00	1,535,000.00	315,800.00	1,219,200.00	21%
<b>Харууд, хамгаалалтын зардал</b>		<b>645,000.00</b>	<b>645,000.00</b>	<b>842,000.00</b>	<b>297,200.00</b>	<b>544,800.00</b>	<b>35%</b>
<b>Үл хөдлөх хөрөнгийн татвар</b>		<b>1,162,300.00</b>	<b>1,162,300.00</b>	<b>1,282,500.00</b>	<b>1,282,500.00</b>	<b>-</b>	<b>100%</b>

Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Биеийн тамгын уралдаан, тэмцээн	500,000.00	500,000.00				
<b>Сургалт сөмнөр</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>	<b>950,000.00</b>	<b>300,000.00</b>	<b>650,000.00</b>	
Дотоод сургалт	1,000,000.00	1,000,000.00	950,000.00	300,000.00	650,000.00	32%
<b>Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг</b>	<b>7,550,000.00</b>	<b>7,550,000.00</b>	<b>5,420,000.00</b>	<b>3,050,000.00</b>	<b>2,370,000.00</b>	
Нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг	5,550,000.00	5,550,000.00	5,420,000.00	3,050,000.00	2,370,000.00	56%
Шагнал урамшуулал, баяр ёслол	2,000,000.00	2,000,000.00				
Эмчилгээний төлбөр	960,000.0	960,000.0	930,400.00	240,000.00	690,400.00	26%
<b>НИНТ ОРЛОГЫН ДҮН:</b>	<b>528,663,326.00</b>	<b>528,663,326.00</b>	<b>546,900,872.38</b>	<b>518,386,235.94</b>	<b>28,514,636.44</b>	
Буулт хөөрөлтийн орлого	177,800.00	177,800.00	100,000.00	30,000.00	70,000.00	30%
Санхүүжилт	527,985,526.00	527,985,526.00	546,000,872.38	518,007,455.94	27,993,416.44	95%
Бусад орлого	500,000.00	500,000.00	800,000.00	348,780.00	451,220.00	44%
Ажилтны тоо	16	16	16	16		

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал” ТӨХК-ийн Монгол улсын нутаг дэвсгэр, агаарын зайд эдийн засгийн зр ашигтай агаарын навигацийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, удирдан чиглүүлэх, зохион байгуулалтаар хангахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Нисэх буудлын үйл ажиллагаа” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн гишүүдийн тоо 1 ба 100 хувь төр эзэмшиж байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал” ТӨХК нь 2005 оны 10 сарын 11-ний дөр 970001098 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ бүхий, 9038922 регистрийн дугаартайгаар Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Булнай, Дархан-Уул өөрийн байранд үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

АТҮГ-ын даргын 1993 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 01 дугаар тоот тушаалаар үүсгэн байгуулагдсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт нь Монгол улсад мөрдөгдөг Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам заавар, НББОУС, СТОУС-д нийцсэн байна.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал” ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	7,178.0	13,217.3	6,039.3
Татвар, НДШ-ийн авлага	15.8		-15.8
Бусад авлага	176.2	274.0	97.8
Бараа материал	201,320.1	191,584.7	-9,735.4
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		380.0	380.0
Үндсэн хөрөнгө	423,643.9	420,040.7	-3,603.2
Биет бус хөрөнгө	4,190,180.0	4,189,773.0	-407.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	30,061.5	28,390.3	-1,671.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,852,575.5</b>	<b>4,843,660.0</b>	<b>-8,915.5</b>
Татварын өр		2.0	2.0
Бусад богино хугацаат өр төлбөр	315.8		-315.8
Өмч: төрийн	4,186,718.0	4,186,718.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	104,153.7	104,153.7	-
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	561,388.0	552,786.3	-8,601.7
<b>Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн дүн</b>	<b>4,852,575.5</b>	<b>4,843,660.0</b>	<b>-8,915.5</b>

Тус байгууллага нь бэлэн мөнгөний кассгүй бөгөөд Хаан банкин дахь 5498020411 тоот төгрөгийн 1 харилцах данстай. Харилцах дансны үлдэгдэл 13,217.3 мянган төгрөг. Тайлант хугацаанд 455,499.8 мянган төгрөгийн орлогын, 449,460.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан.

Бусад авлага дансны үлдэгдэл 97.8 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүмүүсээс авах авлага, шатахууны үлдэгдэлээс шалтгаалсан байна.

Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансны үлдэгдэл үүссэн шалтгаан нь дараа тайлангийн тооцоо данснаас хамааралтай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 191,584.7 төгрөг болж 9,735.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнө нь бэлтгэсэн бараа материалынхаа үлдэгдлийг бүрэн гүйцэд ашиглаж зарцуулалт хийж, бараа нөөцлөөгүй байдлаас шалтгаалжээ.

Тайлант онд 61,603.4 төгрөгийн бараа материал худалдан авч, 71,338.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Бараа материал дансанд конторын зориулалттай материал, бусад материал, түлш шатахуун, сэлбэг хэрэгсэл зэрэг багтаж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,603.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдэлийн тооцоололтой хамааралтай байна. Тайлант хугацаанд 14,545.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан. ИНЕГ буюу дотоодын хөдөлгөөнөөр 54,181.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9,643.7 мянган төгрөгийн тавилга эд хогшилыг олж бэлтгэсэн.

Биет бус хөрөнгө 0.5 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэл нөлөөлжээ.

Татварын өр дансын үлдэгдэл нь ХХОАТ-ын өрийг үлдэгдэл байна.

Эзэмшигчдийн өмч дансны үлдэгдэл 4,186,718.0 мянган төгрөг байна. Гэвч байгууллагын гэрчилгээн дээр 1 хувьцаа эзэмшигч, өөрийн хөрөнгийн дүн 685.6 мянган төгрөг байна.

#### **3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал” ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

2020 оны 9/20 дугаар тушаалаар “Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал” ТӨХК-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 550,900.0 мянган төгрөгөөр, нийт 540,861.4 мянган зардлыг төгрөг байхаар тогтоосон байна.

Өмнөх онд тус байгууллага нь 50,995.7 мянган төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол тайлант онд 8,601.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан.

Гүйцэтгэлээр 521,494.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 530,095.8 мянган төгрөгийн зардал гарган, 8,601.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## **4. Аудитын тайлан**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад “Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал” ТӨХК-тэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал” ТӨХК-д 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Тосонцэнгэл сум дахь Нисэх буудал” ТӨХК нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг дахин тогтоож АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор

сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 3,650.4 төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 521,494.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,214.9 төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 3,650.4 мянган төгрөгөөр тогтоосон.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага байхгүй.

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Ибаримтын бүрдүүлэлтэнд анхаарч ажиллах

## **8. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 80,275.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 80,275.6 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа.

### **8.1 Залруулсан алдаа байхгүй.**

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 80,275.6 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- ✓ Илрүүлэлт: ИНЕГ-аас ирсэн Тавилга эд хогшил 9,643,733.33 төгрөгийн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 7,848,409 төгрөгийг тайлант хугацааны элэгдлээр нэмж тодруулга тайланд бичсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөнө", 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь

Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" мөн Иж бүрэн байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.

- ✓ Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн тодруулгыг зөв тайлагнах
- ✓ Илрүүлэлт: Орлогын тайлангаас татагдах тайлант үеийн ашиг, алдагдал (8,601,669.15) төгрөгийг Эзэмшигчдийн өмчийн тайланд буруу бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" мөн Иж бүрэн байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.
- ✓ Өгсөн зөвлөмж: Эзэмшигчдийн өмчийн тайланг зөв гаргах
- ✓ Илрүүлэлт: ИНЕГ-аас ирсэн машин тоног төхөөрөмж 54,181,818.18 төгрөг, Тавилга эд хогшил 9,643,733.33 төгрөг, нийт 63,825,551 төгрөгийн үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд худалдан авсан үндсэн хөрөнгөнөөс салгаж бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" мөн Иж бүрэн байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.
- ✓ Өгсөн зөвлөмж: Хандиваар орж ирсэн болон худалдан авсан хөрөнгүүдийг зөв салган бүртгэх

## **8.2 Төлбөрийн акт өгөгдөөгүй.**

## **8.3 Албан шаардлага өгөгдөөгүй.**

## **8.4 Зөвлөмж өгөгдөөгүй.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

**7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	3	80.2	3	80.2						
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	0									0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>3</b>	<b>80.2</b>	<b>3</b>	<b>80.2</b>						

,